



**ХЭНТИЙ АЙМГИЙН
БОР-ӨНДӨР СУМЫН НЭГДСЭН ЭМНЭЛГИЙН
ДАРГЫН ТУШААЛ**

2023 оны 12 сарын 27 өдөр

Дугаар A/20

Бор-өндөр сум

**Нэгдсэн эмнэлгийн эд хөрөнгийн
тооллого зохион байгуулах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 70 дугаар зүйлийн 70.2, 70.2.2, 72 дугаар зүйлийн 72.1 дэх заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. Нэгдсэн эмнэлгийн 2023 оны жилийн эцсийн эд хөрөнгийн тооллогыг 2024 оны 12 дугаар сарын 27-ны өдрөөс 2024 оны 01 дүгээр сарын 12-ны өдрийг хүртэл зохион байгуулсугай.

2. Эд хөрөнгийн тооллогын ажлын хэсгийн комиссыг доорх бүрэлдэхүүнтэй томилсугай.

Комиссын дарга:	Д.Боргил	Өмч хамгаалах комиссын дарга
Нарийн бичиг:	М.Энхтуул	Ахлах сувилагч
Гишүүд:	Д.Алтантуяа	Эрчимт эмчилгээ, унтуулгын сувилагч
	Б.Номинчимэг	Цахим бүртгэлийн ажилтан
	Э.Оюунболор	Нярав
	А.Лхагвасүрэн	Мэс заслын сувилагч

3. Эд хөрөнгийн тооллогыг үнэн зөв, чанартай, нэг бүрчлэн жагсаалтаар бүртгэн, тайланг 2024 оны 01 дүгээр сарын 12-ны өдөр Үйл ажиллагаа эрхэлсэн дарга (Б.Энхмаа)-д танилцуулахыг комиссын дарга (Д.Боргил)-д, эд хөрөнгийг тоолоход бэлэн байдлыг хангаж, данс бүртгэл, эд хөрөнгө эзэмшигчийн картыг бэлэн байлгахыг нярав (Э.Оюунболор)-т тус тус даалгасугай.

ДАРГА

А.БАТБААТАР

